



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 14 өдөр

Дугаар А/100

Жаргалтхаан

Аймаг, сумын аварга шалгаруулах
тэмцээн зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 03 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сумын аварга шалгаруулах “Адуучин” тэмцээнийг 2024 оны 08 дугаар сарын 11-ний өдөр, аймгийн аварга шалгаруулах “Адуучин” тэмцээнийг 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдөр тус тус зохион байгуулсугай.

2. Аймаг, сумын аварга шалгаруулах “Адуучин” тэмцээнийг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Ганбат - Сумын Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: Г.Мөнхсайхан – Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн

Гишүүд : С.Мөнхдэлгэр – Засаг даргын Тамгын газрын дарга

Д.Энхболд – Гичгэнэ багийн Засаг дарга

Б.Жаргал – Төвийн багийн Засаг дарга

Т.Батбаяр – Сумын Адуучдын холбооны тэргүүн

Э.Эрдэнэхүү - Санхүүгийн албаны дарга

Т.Сүрэнцэцэг - Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Н.Түвшинжаргал – Эрүүл мэндийн төвийн эрхлэгч

А.Бадамсэд - Сумын хэсгийн төлөөлөгч

Ж.Ариунгэрэл - Соёлын төвийн даргын албан

үүргийг түр орлон гүйцэтгэгч

Б.Чинбат – Иргэний танхимын ажилтан

Г.Сугар – Мэргэн Жонон ХХК-ны малын эмч

Г.Жавзанжамъян - Нярав

Data (D:) /A4 zahiramj/

232401245

ГА Л.Д.

Л.ЦЭНГЭЛ